



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№137 /351/

2022.08.05

Тусгай дугаар

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 089 ДҮГЭЭР АНГИЙН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДЧИЛГЭЭГ ДЭВШҮҮЛЬЕ!

### МЭНДЧИЛГЭЭ

### ТҮҮХЭН ЗАМНАЛЫН ТОВЧООН



Тэртээ 1921 онд жанжин Д.Сүхбаатарын санаачилга, оролцоотойгоор анх байгуулагдаж байсан "Цахилгаан тэрэгний хороо" өдгөө 100 жилийн түүхт ойтойгоо золгож буй энэ тэмдэглэлт өдөр Цэргийн гавьяаны улаан тугийн одонт тус ангийн үе үеийн жолооч тээвэрчид, ахмад дайчид Та бүхэндээ чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж!



Монгол Улсын авто тээврийн салбарын анхдагч байгууллагын түүх нь 1921 оны Ардын хувьсгалын ололтыг бататгах, 1939 оны Халх голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайныг ялалтад хүргэх, улс орон, Зэвсэгт хүчний хөгжил дэвшлийг хангахад бодитой хувь нэмэр оруулж, эгнээнээсээ олон алдартнууд, энхийг сахиулагчдыг төрүүлсэн тэмцэл, хөдөлмөр, алдар гавьяаны 100 жилийн бахархалт он жилүүд байж ирснийг онцлон тэмдэглэж байна.

Цэргийн авто тээврийн хангалт, үйлчилгээний бүхий л чиглэлийн үүргийг өдөр тутамд хариуцлагатай гүйцэтгэж ирсэн та бүхний сэтгэл зүтгэл, улс орондоо төдийгүй даян дэлхийд энхийг сахиулж байгаа Монгол цэрэг эрстэй мөр зэрэгцэн байгаль цаг уурын хүнд нөхцөлд техникийн аливаа сааталгүй алба хааж байгаа дайчдынхаа ур чадварыг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлага, хамт олон өндрөөр үнэлж байдаг юм

ЗХЖШ-ын Тээвэр үйлчилгээний тусгай батальон нь Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний удирдлагын байгууллагуудад үйлчлэх, Төрийн ёслолын болон Цэргийн төв эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ, хот, хөдөөгийн шуурхай дуудлага, ачаа тээврийн хангалтын үүргээ ямагт нэр төртэй гүйцэтгэж ирсэн дайчин

уламжлалаа хадгалж, Зэвсэгт хүчний байгуулалтыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг анги, салбарынхаа түвшинд бүтээлчээр хэрэгжүүлэн, ангийн бие бүрэлдэхүүн, техникийн бэлэн байдлыг цаг ямагт өндөр түвшинд хангаж ажиллана гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлж.

Төрөлх ангийнхаа 100 жилийн ойг бахархал дүүрэн тэмдэглэж байгаа цэргийн тээвэрчид Та бүхэндээ дахин баярын мэндчилгээ дэвшүүлж, аяны зам тань ямагт дардан байхын ерөөлийн өргөө!

Цэргийн тээвэрчдийн яруу алдар бадартугай.  
**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА  
ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ**

Их жанжин Д.Сүхбаатарын санаачилга, Ардын Засгийн газрын Цэргийн явдлын яамны Тэргүүн сайдын 1922.01.05-ны өдрийн тушаалаар "Цахилгаан тэрэгний хороо"-г байгуулснаар Монгол Улсын Авто тээврийн ангийн үндэс суурь тавигдсан түүхтэй. ЦЯЯ-ны тэргүүн сайдаас 1922 оны Октябрийн хувьсгалын 5 жилийн ойг тэмдэглэх тухайд гаргасан тушаалаа: "Ёслолын жагсаал явуулахад... Их бууны хороо дараа нь Цахилгаан тэрэгний хороо жагстугай" гэсэн байдаг нь тус анги Монгол Улсын Авто тээврийн анхны байгууллага төдийгүй, авто техникийн анхны параддыг зохион байгуулж оролцох болсныг тодхон гэрчилж байна. "Цахилгаан тэрэгний хороо"-г Бүх Цэргийн Зөвлөлийн 1924.01.01-ний өдрийн тогтоолоор "Уурын тэрэгний хороо" болгон өргөтгөж бүрэлдэхүүнд нь "Сургуулийн салаа" байгуулахад Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар: "Бид ирээдүйд олон машинтай болно. Та нар оньсон техникийг сайн судлах хэрэгтэй. Үүнийг судлахад өөрийн биеийн хүчийг шавхан дайчилж өдөр, шөнө ялалгүй суралцах хэрэгтэй. Монгол хүн техник эзэмших болно. Бид цэргийн ба ард түмний тээврийг үргэлжлүүлэн их хэмжээгээр тээвэрлэх болно" хэмээн онцлон хэлсэнээ үзэхэд Монгол улсад техникийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажил энэ ангиас эхэлсэн болох нь түүхэн баримтаар нотлогдож байгаа юм. Энэ мэт олон зүйлийн анхдагч болсон Уурын тэрэгний хороо нь тухайн үеийн улс орны нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Ардын Намын Төв Хороо, Ардын Засгийн Газар, Бүх цэргийн зөвлөлд бүхэлд нь үйлчилж байжээ.

Монгол Улсын анхны Авто тээврийн контор, автомашины аж ахуйг Намын Төв Хороо, Ардын Засгийн Газрын 1925.07.15-ны өдрийн хамтарсан шийдвэрээр Уурын тэрэгний хорооны бүрэлдэхүүнээс "Монгол тээх" буюу "Тээх нэвтрүүлэх хороо" нэртэйгээр 12 автомашин, 112 мянган төгрөгийн хөрөнгөтэйгөөр зохион байгуулсан нь өдгөө БНМАУ-д Авто тээвэр үүсэж хөгжих эхлэлийг тавьсан юм. 1932 онд баруун

аймгуудад хувьсгалын эсэргүү бослого хөдөлгөөн эхэлснээр цэргийн хангалтын материал хэрэгслэлийг олноор тээвэрлэх шаардлага үүсч Ардын хувьсгалт улаан цэргийн зөвлөлийн 1932.04.29-ний өдрийн тогтоолоор "Цэргийн тээх нэвтрүүлэх хороо"-г байгуулж бүрэлдэхүүнд нь Засварын газар, Сургуулийн салаа, Уурын тэрэгний ба Ердийн хөсгийн дивизион багтаж үүргээ гүйцэтгэж байсан нь хожмоо Зэвсэгт хүчний 026, 011, 107 дугаар ангиудын анхдагч суурь нь болжээ. Улс орныг батлан хамгаалах салбар өргөжлийн хэрээр техникийн тоо нэмэгдэж, хуягт техникийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх шаардлагын дагуу Сургуулийн салааг өргөтгөн шинээр зохион байгуулснаар Ардын цэргийн 107 дугаар анги буюу "Цэргийн авто жолооны сургууль" үүсч тус ангиас өрх тусгаарлан байгуулагджээ. Бүх цэргийн жанжны тушаалаар "Жанжин штабын авто суман"-г "Цэргийн яамны граж" болгон өргөтгөн зохион байгуулж, 1939 оны Халх голын дайны үеэс улсынхаа дархан хил хязгаарыг хамгаалж байсан Монгол Ардын Хувьсгалт цэргийн дээд удирдлагын хамгаалалт, үйлчилгээг тусгайлан хариуцуулах болжээ. БНМАУ-ын Батлан хамгаалах яамны сайдын 1973.07.20-ны өдөр баталсан шинэ орон тоо, зохион байгуулалтын дагуу тус баазыг Зэвсэгт хүчний Жанжин штабын "Хамгаалалт үйлчилгээний тусгай батальон" болгон өргөтгөж, бүтцэд нь Техник үйлчилгээний тусгай рот, Жагсаал, Байлдааны машины салаа, Шуурхай үйлчилгээний тусгай салаа, Авто засварын ба Ар тал, Хөгжлийн тусгай салаадыг тус тус байгуулжээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн /1966.03.24/ зарлигийг үндэслэн БХЯ ны сайдын /1974.11.24/ тушаал гарч тус анги байлдааны анхны тугаа хүлээн авчээ. Байлдааны тугийг ангийн бие бүрэлдэхүүнд БХЯ ны орлогч сайд, АААТУГ-ын дарга хошууч генерал Д.Бямбаа гардуулж, ангийн захирагч дэд хурандаа О.Раднаабазар гардан авч байв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992.04.18-ны өдрийн зарлигийг үндэслэн Монгол Улсын БХ-ын сайдын 2002.03.09-ний өдрийн тушаалаар Хамгаалалт үйлчилгээний тусгай батальонд байлдааны шинэ туг гардуулав.

Зэвсэгт Хүчний түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн "Хэрлэн-73", "Говь-77", "Найрамдал-79" "Зоргол -87 "Дархан-1", "Дархан-2", "Дархан-3" "Сэлэнгэ-1, 2, 3, 4 "Хааны эрэл-2005, 2006, 2007, 2008, 2009,2010, 2011", Энэтхэг Монголын хамтарсан хээрийн сургууль, Монгол-Катарын хамтарсан хээрийн сургуулиудыг тус тус зохион байгуулахад эл ангийн бие бүрэлдэхүүн оролцож, Батлан хамгаалах яам, Зэвсэгт Хүчний Жанжин Штабын хээрийн болон хөдөлгөөнт командын байруудыг иж бүрнээр дэлгэж, цэргийн дээд удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд шуурхай үйлчлэн ажилласан нь командлалаас тавигдсан үүргээ "Онцсайн" биелүүлсэн гэсэн үнэлэлт авч ангийнхаа дайчин замналын түүхэнд шинэ шинэ хуудсуудыг нэмсээр байна.

Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, БХ-ын сайдын тушаалын дагуу ЗХЖШ-ын даргын /2003.03.20-ний өдрийн тушаалаар Батлан хамгаалах салбарын бүх төрлийн тээврийн үйлчилгээнээс гадна улс орны хэмжээний ургац хураалт, өвс, тэжээл тээвэрлэлт, цас, зудын хүнд нөхцөлд тэргүүн эгнээнд нэр алдраа дуурсган үүрэг гүйцэтгэж, эгнээсээ олон арван алдартнуудыг төрүүлсэн түүхэн замналтай ЗХ-ний 026 дугаар ангийг татан буулгаж, ЗХ-ний 089 дүгээр ангийг нэгтгэн, шинэ бүтэц орон тоонд шилжүүлсэн юм.

Манай хамт олон 2003 оноос "Хангалт үйлчилгээний тусгай батальон" нэртэйгээр Батлан хамгаалах Яам, ЗХЖШ-ын үйлчилгээ, Зэвсэгт хүчний бүх төрлийн ачаа тээвэрлэлт, Төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ, ЗХКТГ-ын түргэн тусламжийн хот доторх болон алсын дуудлага, хот хоорондын захилгалт ачаа тээвэрлэлтийн үүргийг гүйцэтгэж, "Офицер, ахлагч нарын суралцах, өөрийгөө хөгжүүлэх орчныг сайжруулах замаар цэргийн сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулж, ангийн байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх, техникийн бэлэн байдал, үйлчилгээний соёлч шуурхай байдлыг сайжруулах"-ыг үндсэн зорилго болгон ажиллаж байна.

## ЦЭРГИЙН ТЭЭВЭРЧИД 100 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭЖ БАЙНА



Тэртээ 1921 оны энэ өдөр "Цахилгаан тэрэгний хороо" нэртэйгээр байгуулагдаж байсан Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн 100 жилийн ой тохиож байна.

100 жилийн ойн ёслолын арга хэмжээнд БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, Үндэсний батлан хамгаалахын Их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсийн дарга хурандаа Б.Өлзийхуяг, Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн захирагч хурандаа Б.Бямбаа, бэлтгэл байгаа бригадын генерал Д.Энхбаатар болон тус ангийн үе үеийн удирдлага хамт олон, ахмад дайчид, бие бүрэлдэхүүн оролцож байна.

Баярын хурлын үндсэн илтгэлийг ангийн захирагч хурандаа Б.Бямбаа

тавьж, улмаар ангийн ахмад дайчдын төлөөлөл сэтгэгдлээ хэллээ. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний удирдлагын байгууллагуудад үйлчлэх, Төрийн ёслолын болон Цэргийн төв эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ, хот, хөдөөгийн шуурхай дуудлага, ачаа тээврийн хангалт гээд энэ ангийнхны ажил дундаршгүй. Тэдний энэ л хийж ирсэн цаашид хийх ажил үйлсээр өнөөдөр салбарын бие бүрэлдэхүүн бахархан буй юм.

Баярын арга хэмжээний хүрээнд эрхэлсэн ажил, мэргэжилдээ амжилт гаргасан доорх алба хаагчдыг салбарын болон бусад шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд: Эх орны төлөө III хүндэт тэмдгээр ахлагч Д.Жаргалсүрэн, Л.Амартүвшин, Э.Мөнх-Эрдэнэ, Г.Мягмаржав,

Б.Ганцэцэг, дэд ахлагч Д.Лхагвасүрэн нарыг, Эх орны төлөө I хүндэт тэмдгээр ахлах ахлагч Б.Даваанямыг, Дайчин алдар III медалиар ахмад С.Сантогтох, Д.Орлом, С.Төмөрхүү, дэслэгч Ц.Цогтбаяр, ахлагч Х.Чулуун-Эрдэнэ нарын 7 алба хаагчийг, Дайчин алдар II медалиар хошууч Ж.Батбаяр, ахлах ахлагч Б.Бат-Өлзий, Ц.Ариунбат нарыг тус тус шагналаа. Мөн Ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар Б.Цолмон, А.Цэрэнлхам, Ж.Хишигдолгор нарын 7 алба хаагчийг, ЗХЖШ-ын жуух бичгээр хошууч Н.Од, ахлах ахлагч М.Даваажав нарыг тус тус шагнав. Түүхт ойн энэ өдөр Д.Оргилбаатар дэслэгч цол гардан офицерын эгнээнд орсон бол дэд ахлагч, Д.Жаргалсүрэн, Б.Цэрэнсамбуу, Б.Пүрэвжав, Б.Буянбаатар, Б.Мөнхбаяр нар ахлагч цол гардан авлаа.





# ТӨР ЦЭРГИЙН ЁСЛОЛ, ХҮНДЭТГЭЛИЙН АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ ИРСЭН ТҮҮХЭЭС



Батлан хамгаалахын төв архивын түүхэн баримтад тулгуурлан эрдэмтэд, судлаачдын олж тогтоосноор 1922 оны 11 дүгээр сард тус ангийн бүрэлдэхүүн анх цэргийн ёслолын жагсаалд оролцсон бол 1920-оод оны сүүлчээс эхлэн жил бүрийн цэргийн наадам, Октябрийн баярын жагсаалд цэргийн зарим техник, түүний дотор манай ахмадууд өөрсдийн эзэмшиж байсан машин тэрэгтэйгээ оролцсон тухай дурссан нь бий.

Ардын хувьсгалын 35 жилийн ойн баярын парадын өмнө тухайн үеийн ЗХУ-аас тусгай зориулалтын ЗИС-110 машин анх, Парад командлагчаар Ардын цэргийн Жанжин штабын дарга, дэслэгч генерал Б.Цог, жолоочоор нь ахмад н.Цэгмид жолоодон оролцсон байна. Энэхүү ЗИС-110 машин 1960-аад оны сүүл хүртэл гадаадын Төр засгийн өндөр дээд хэмжээний зочид, төлөөлөгчдийг угтан авах, үдэх болон цэргийн парад, жагсаал зэрэг бүхий л ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд

үйлчилж ирсэн байдаг. 1971 онд Монгол Ардын хувьсгалын 50 жилийн ойн парадд зориулж, мөн ЗХУ-аас тусгай тоноглол бүхий 2 ширхэг задгай тэвштэй ГАЗ-24 машин бэлэгт ирэхэд БХЯ, ЗХЖШ-аас тусгай комисс гарган хүлээн авч, улмаар тус ангид албан ёсоор хүлээлгэн өгч тусгай гараашинд байрлуулах болсон юм.

Ийнхүү Ардын хувьсгалын 50 жилийн ойн парад болоход ёслолын жагсаалыг хүлээн авсан БХЯ-ны сайд хурандаа генерал Б.Доржийн 001 дугаарын машины жолоочоор дэд хурандаа М.Гүндаш, Парад командлагч дэслэгч генерал Ж.Ёндонгийн 002 дугаарын машины жолоочоор ахмад н.Лувсандондог /хожим дэд хурандаа болсон/ нар оролцож үүргээ амжилттай гүйцэтгэсэн билээ. Энэ 2 нэгж автомашины дараа жилүүдийн парад, Ёслолд манай ангийн дэслэгч Т.Оюунбазар /хожим хурандаа, Батлан хамгаалахын төв архивын дарга асан/, ахлах дэслэгч Бямбасүрэн нар маань

олон жил барьж оролцжээ. Ардын хувьсгалын 60 жилийн ойн өмнө нэгт 10 жил ёслолын ажиллагаанд ашигласан дээрх 2 нэгж автомашиныг шинэчлэн солих шаардлагатай болсон тухай ЗХУ-ын талд санал тавьсан боловч Зөвлөлтийн талаас уг машинуудад иж бүрэн хийж өгөхөөр болсон тухайгаа мэдэгдэв. ЗСБНХУ-ын БХЯ-ны парадын техник хариуцсан албаны дарга хурандаа мөн автын инженер хурандаа, автын засварчин 3 хүн тусгай томилолттой ирэхэд БХЯ-ны орлогч сайд дэслэгч генерал Ж.Ёндон, ЗХЖШ-ын орлогч хошууч генерал П.Мөнхдорж нар хүлээн авч уулзан, засварын ажлыг АА-ийн дугаар ангийн байранд хийхээр шийдвэрлэсэн байна. БХЯ-ны Авто хуягт танкийн газрын дарга хурандаа Б.Эрдэнэбат, зөвлөх мэргэжилтэн Зөвирөө нар тус ангид биечлэн очиж уг 2 нэгж автомашинд засвар хийж байрыг тусгайлан бэлтгэх үүргийг хурандаа н.Лувсандондог өгч, АА-ийн дугаар

ангиас Ерөнхий инженер ахмад Б.Хүрэлбаатарыг томилон ажиллуулах болсон юм. Ингээд ЗХУ-ын БХЯ-аас томилогдон ирсэн 3 мэргэжилтэн, ахмад Б.Хүрэлбаатар нарын 4 хүн тус 2 автомашины бүрэн задалж, Орос дахь үндсэн үйлдвэрээс нь цоо шинээр авчирсан мотор, бусад сэлбэг, тусгай тоноглолыг 2 сарын хугацаанд угсарч дуусган, Улаанбаатар-Дарханы замд 500 км-ын туршилтын жолоодлого хийж, БХЯ, ЗХЖШ-аас томилогдсон комисст тусгай актаар хүлээлгэн өгч байжээ.

Ардын хувьсгалын 60 жилийн ойн Цэргийн ёслолын жагсаалд БХЯ-ны сайд, хурандаа генерал Ж.Ёндонгийн 1 дүгээр машины жолоочоор дэд хурандаа н.Нохойжав, парад командлагч ЗХЖШ-ын

1990-ээд оны эхээр Цэргийн парад хэдэн жил завсарласны дараа Ардын хувьсгалын 75 жилийн ойг анх Төв цэнгэлдэх хүрээлэнд хийхэд Парад хүлээн авагчаар Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Ш.Жадамбаа, жолоочоор нь хурандаа н.Содов, парад командлагч, ЗХЖШ-ын орлогч, Улаанбаатар цэргийн хүрээний дарга хошууч генерал Б.Шагдарын жолоочоор хурандаа Б.Хүрэлбаатар нар томилогдон үүрэг гүйцэтгэсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зөвсөгт хүчний Ерөнхий командлагчийн зарлиг буулгасны дагуу Монгол Улсын "Төрийн далбааны өдөр"-ийг тохиолдуулан Цэргийн ёслолын жагсаал явуулахтай холбогдуулан 2010 онд 2 ширхэг УАЗ-469 машиныг

зориулан өөрсдийн хүчээр өөрчлөн тоноглов. Эдгээр машины жолоочоор хурандаа С.Уртнасан, дэд хурандаа Д.Мөнхбаатар, дэд хурандаа Т.Даваахүү, сургагч ахлагч Б.Замбалгарав нарын офицер, ахлагч нар жолоодож, хошууч генерал Р.Сүхбат, бригадын генерал Б.Баярмагнай нарын хамт ёслолын жагсаалын тусгай машины жолоочоор үүрэг гүйцэтгэж байв.

2022 онд Монгол Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн ёслолын парад хүлээн авагчаар Монгол Улсын Засгийн Газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Г.Сайханбаяр, ёслолын машины жолоочоор нь хурандаа С.Уртнасан, парад командлагчаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч, Улаанбаатар



нэгдүгээр орлогч, Улаанбаатар цэргийн гарнизоны дарга хошууч генерал Г.Махбариадын 2 дугаар машины жолоочоор ангийн ерөнхий инженер хошууч н.Данаа нар жолоодон оролцсон.

тусгайлан тоноглож, ёслолын ажиллагаанд оролцуулсан бөгөөд мөн онд анх удаа АНУ-аас 2 нэгж тусгай тоноглол бүхий "Л/гапд1ег" машин, АНУ-аас 2011 онд дахин 1 нэгж "Л/гапд1ег" орж ирснийг ёслолд

цэргийн хүрээний дарга бригадын генерал С.Ганбямба, жолоочоор нь хурандаа Д.Туул, Жанжин тугийн машины жолоочоор ахмад С.Төмөрхүү нар үүргээ амжилттай гүйцэтгэсэн юм.

## Дурсамж, дурдатгал 26 ЖИЛИЙН ХӨДӨЛМӨР, ЗҮТГЭЛЭЭ ЗОРИУЛАН АЖИЛЛАЖЭЭ

Зөвсөгт хүчний 089 дүгээр ангийн жолооч асан бэлтгэл ахлах ахлагч П.Ганболд:

-Ангийнхаа түүхэн ойн босгон дээр гавьяаныхаа амралтад сууж байгаадаа туйлын бахархалтай

болон Төрийн ёслолын автобусны жолооч хүртэл нийт 26 жилийн хөдөлмөр, зүтгэлээ зориулсан гэж



байна. 1994 онд Ардын Армийн 016 дугаар нэгтгэлийн 105 дугаар ангид хугацаат цэргийн албанд татагдсанаар би энэ салбартай анх холбогдож байлаа. Бага залуугаасаа л жолооч болох хүсэл мөрөөдөлд хөтлөгдөж өнөөдөр 100 жилийн түүхийг өртөөлж буй энэ ангид 1996 онд урсгал засварчнаар ажлынхаа гарааг эхэлж байв. Ер нь бол энэ ангийн жолооч бүр л засварчнаас эхэлдэг уламжлалтай. Жолооч хүн гэдэг машин, техникээ засаж, янзалж чаддаг, хэнээс ч илүү мэддэг байх ёстой шүү дээ. Дараа нь би даргын зохион гэх хариуцлагатай албан тушаалд томилогдож байв. Ингэж л миний жолооч болох эхлэл тавигдсан. Ангид 2 засварчнаас нь эхлээд даргын, хөдөө ажлын машины

бодохоор хамгийн бахархалтай санагдаж байна. Цаг хугацаа гэдэг харвасан сум шиг л өнгөрчээ. Саяхан ангийнхаа засварын байрны хажууд юугаа ч хийхээ мэдэхгүй залуу зогсож байсан бол өнөөдөр ахмад үеийнхний эгнээнд хэдийнээ шилжсэн байна гэдэг гайхалтай санагдаж байна. Зөвсөгт хүчинд алба хаасан хугацаандаа Сьерра-Леон болон Өмнөд Судан Улсад явагдсан энхийг сахиулах ажиллагаанд нийт гурван удаа жолоочоор үүрэг гүйцэтгэсэн. Цэргийн жолоочид бидний нэгэн онцлог бол энэ. Дээд удирдлагаас өгсөн үүргийг цаг алдалгүй гүйцэтгэж, тэр ч бүү хэл хилийн чанадад ч монгол цэрэг гэдэг нэрийг гаргаж явсандаа омогшиж явах болно оо.

## БИДНИЙ АМЬДРАЛЫН 40 ШАХАМ ЖИЛ ЭНЭ АНГИТАЙ САЛШГҮЙ ХОЛБООТОЙ

Онц тээвэрчин Ө.Цэцэгээ

-Би Архангай аймгийн Өгийн нуур сумын харьяат хүн. 1981-1999 оныг хүртэл Ойн нэгдүгээр баазад ашиглалтын тоо бүртгэгч, Ойн яамны авто бааз болон "Мердиан" ХХК-д нярваар ажиллаж байгаад 1999

тайлагнаж, тодорхой үүрэг чиглэл авч түүнийг бүрэн дүүрэн хэрэгжүүлдэг ийм л ажил.

Миний хань Архангай аймгийн Хашаат сумын уугуул бэлтгэл ахлах ахлагч Ш.Баяраа гэж хүн бий. Насаараа энэ сайхан ангид жолоочоор ажилласан, алтан шар замын эздийн нэг.



онд энэ сайхан алтан босготой ангид диспетчерээр томилогдон 2013 оныг хүртэл ажиллаад гавьяаныхаа амралтад гарсан даа. Маш сайхан хамт олонтой гар сэтгэл нийлж ажилладаг байлаа. Эрчүүд давамгайлсан байгууллага тул ёстой л өөрийгөө эмэгтэй хүн гэдгээ умартан, шижигнэсэн сайхан эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллаж байсандаа баяр бахдал дүүрэн явдаг юм. Диспетчерийн ажил их хариуцлагатай, ёс зүйтэй байхыг шаарддаг ажил нийт гурван удаа жолоочоор хуудасны бөглөлт, ажлын цаг ашиглалт, ажил үүргийн биелэлт, машин техникийн бүрэн бүтэн байдал зэргийг ашиглалтын албаны даргын хамтаар шалгаж, тогтмол хяналт тавин ажиллана. Мөн өглөө бүр ангийн захирагч, удирдлагад 24 цагийн ажлаа

Анх 1974 онд хугацаат цэргийн албанд татагдаж тухайн үеийн Ардын Армийн 107 дугаар анги буюу Авто жолооны сургуульд эхний жилдээ алба хааж, жолооч болоод л 089 дүгээр ангид улиран ажилласан юм. Ингээд бодохоор бидний амьдралын 40 шахам жил армитай, тэр тусмаа "Штабын гарш" нэрээрээ ард олондоо алдаршсан энэхүү сайхан ангитай холбоотой. Тийм ч учраас гэрийн бүлийнхээ нэрийн өмнөөс болон хувиасаа ангийнхаа үе үеийн захирагч, удирдлага, нийт бие бүрэлдэхүүнд анги үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж, амьдралд нь аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөхийн сацуу Та бүхэн минь сайхан баярлаарай гэж уламжилъя даа.

## ОЛОН САЙХАН ДУРСАМЖ, АНД НАЙЗУУД МИНЬ БҮГД ЭНЭ АНГИТАЙ ХОЛБООТОЙ

Бэлтгэл, ахлах ахлагч Б.Өлзийсайхан:

-100 жилийн түүхт эл ангид 1994 онд цэрэгт татагдаж ирээд улмаар 1996 онд цэргийн хүн болох замыг сонгосноор ажил амьдралынхаа гараагаа эхлүүлж байв. 1997 оноос 2004 онийг хүртэл эл албанд зүтгэх хугацаандаа Улсын баяр наадмын комисс, Их хурд, Чит хот гэх мэтчилэн гадаад, дотоод дуртхан алтан шаргал замыг дарга нарын тэргийг барьж өнгөрүүлжээ. 2005 оноос цэнхэр дуулгатны эгнээнд шилжиж Иракийн 5 болон 8 дугаар ээлжид жолооч, буудагчийн үүрэг гүйцэтгэсэн. Армийн буян гэдэг хэмжээлшгүй их. Миний ажил амьдралын гараа, олон сайхан дурсамж, анд найзууд минь бүгд энэ ангитай холбоотой. Манай гэр Яармагт байдаг байлаа. Яармагаас Улаанхуаран гэдэг маршрутаар тасралтгүй 24 жилийг явж өнгөрүүлсэн байна. Гавьяаны амралтад суусан хэдий ч 13-р хорооллын ойролцоо явах мөчид сэтгэл гэгэлзүүлсэн, догдлуулсан, яаруулсан, мэдрэмж сүлэлдэн орж ирдэг. Яг л гэртээ эсвэл нутагтаа очиж байгаа мэт дулаахан нандин мэдрэмж энд оршдог. Энэ

ангитай ажил амьдралынхаа түүх дурсамжийг холбосон



ахмад буурлууд олноор хүрэлцэн иржээ. Мөн тухайн үед хамтран ажиллаж, мөр зэрэгцэн зүтгэж байсан хүмүүстэйгээ уулзалдаж, дурсамж дурдатгалаа хуваалцах сайхан байна. Ингээд арвин их түүх, баялаг сайхан дурсамжийг үлдээсэн 089-р ангийн үе үеийн ахмад буурлууд, бидний хойч үе болсон залуус дүү нартаа ойн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.